

ЖИЛИЙН ТАЙЛАН

2016




Эрхэм зорилго	3
Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	4
Онцлох үйл явдлууд	6
Эдийн засгийн үзүүлэлтүүд	7
Санхүүгийн үзүүлэлтүүд	10
Даатгалын үйл ажиллагаа	12
Даатгалын зах зээлийн мэдээлэл	14
Үйл ажиллагаа	18
Ирээдүйн хэтийн төлөв	22
Эрсдлийн удирдлага	24
Компанийн засаглал	26
Төлөөлөн Удирдах зөвлөл	28
Нийгмийн хариуцлага	32
Хараат бус аудиторын тайлан	33
Харилцагчдын сэтгэгдэл	38

ЭРХЭМ ЗОРИЛГО



Бид Монголдоо дэлхийн түвшний санхүүгийн үйлчилгээтэй байгууллага болно.




Эрдэнэт хүмүүн, Эх дэлхий, Эрүүл ашгийг эрхэмлэн харилцагчиддаа үнэ цэнэтэй санхүүгийн үйлчилгээг хүргэж, насан туршийн түнш нь байх болно.



Бид хэтийн зорилт, эрхэм зорилгодоо хүрэхийн тулд дараах зүйлсийг өдөр тутмын үйл ажиллагаандаа эрхэмлэн ажиллана. Үүнд:

ҮНЭТ ЗҮЙЛС



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



ОЙБЕК Н. ХАЛИЛОВ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Хэдийгээр 2016 он сонгууль болон эдийн засгийн орчинтой холбоотой сорилтын жил байсан ч Тэнгэр Даатгал компанийн хувьд амжилтын жил байлаа. Компани нь 1.5 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 4 дахин их ашигтай ажилласан бөгөөд нийт хөрөнгөө 22%-аар өсгөж, 24.7%-ийн өгөөжтэй ажиллаж чадлаа.

Энэхүү амжилтын гол үндэс нь андеррайтингийн бодлогоо сайжруулж, нөхөн төлбөрийн зохистой бодлого гаргаж, үйл ажиллагааны зардлаа хэмнэсэн явдал байлаа.

2016 онд даатгалын нийт хураамж 9.0 тэрбумд хүрч өмнөх оны мөн үеэс 4.0%-аар өссөн үзүүлэлттэй гарлаа.

2016 онд даатгалын хураамжийн харьцаанд дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд: Банк зээлийн үйл ажиллагаагаа хязгаарласны улмаас зуучлагчаар дамжуулсан банкны даатгалын үйлчилгээний хураамж 12.2% аар буурсан бөгөөд харин төв албаны шууд борлуулалт 2015 онтой харьцуулахад 10.0%, салбарын шууд борлуулалт бараг 40%-аар тус тус өссөн байна.

2016 оны туршид байгууллагын мөнгөн урсгалтай шууд холбоотой хариуцлагын даатгалаас бусад бүх шугамын хувьд бүтээгдэхүүний нийт хураамж дунджаар 10.2%-аар өссөн байна.

Бүх төрлийн даатгалын алдагдал өмнөх оны мөн үеэс дунджаар 76 сая төгрөгөөр буурсан нь нөхөн төлбөрийн хэмжээг 16%-д хүргэж бууруулсан бөгөөд ингэснээр өмнөх онд 43.0% байсан алдагдалын харьцааг 37.2%-д хүргэж чадлаа.

Эрсдэлийг үнэлж, хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэмжээтэйгээ уялдуулан даатгалын хамгаалалтын үнэлгээг тогтоох чадамжаараа Тэнгэр Даатгал ХХК нь Монгол улсын даатгалын зах зээлд шилдэг Даатгагчаар танигдаад байна. Үүний үр дүнд бид Монгол улсын даатгалын зах зээлийн дунджаас дээгүүр цэвэр ашигтай ажиллаж чадлаа.

Давхар даатгалын хамгаалалтын санхүүгийн найдвартай байдал, чанарыг оролцуулан даатгалын үйлчилгээгээ олон улсын стандартад нийцүүлснээр Тэнгэр Даатгал ХХК нь зах зээлийн хөгжилд өөрсдийн хувь нэмрээ орууллаа. Манай давхар даатгалын чадамж сүүлийн 2 жилийн туршид нэмэгдсэн бөгөөд 2015 онд 2 сая ам.доллар байсан бол 2016 оны эцэст 10 сая ам.доллар болж өссөн байна.

Тэнгэр Даатгал нь андеррайтингийн чадвар болон онлайн даатгалын платформ зэрэг даатгалын салбарт хийсэн шинэчлэлээрээ бусад даатгалын компаниудын дунд стандарт тогтоосон. Тэнгэр Даатгал нь Санхүүгийн Зохицуулах Хорооны шинэ шаардлагын дагуу нягтлан бодох бүртгэлийн журмаа шинэчилж, үндсэн системийн хувилбараа сайжруулснаараа анхдагч байж чадлаа. Салбаруудаас сар тутам дата авч дүн шинжилгээ хийх боломжтой болсон. Удирдлагын Мэдээллийн систем нь нөхөн төлбөрийн датаг шууд оруулж боловсруулах үйлдлийг дэмждэг боллоо. Бид банкаар дамжуулсан даатгалын сувгийн үйл ажиллагаа, үйлчилгээг хялбаршуулснаар ажилтны тоог нилээд бууруулж, үйл ажиллагааны эрсэдлийн удирдлага, дотоод тайлагналаа сайжруулж, бодит зардалаа хэмнэж чадсан. Бүтээгдэхүүний үнэт чанар, танигдсан байдал, харилцагчийн сэтгэл ханамж, үйлчилгээний чанарын талаарх санал зэргээр даатгалын бүтээгдэхүүн тус бүрийн гүйцэтгэлд илүү гранулар буюу мөчлөгт дүн шинжилгээ хийх боломжтой болсон. Бид дүн шинжилгээ хийх шинэ боломждоо тулгуурлан чиг хандлагаа тодорхойлж эдгээр чиг хандлагуудыг ашиглан харилцагчиддаа илүү үнэ цэнэ авчирах боломжтой болсон.

Тэнгэр Даатгал нь Монгол улсын топ 100 компанийн нийт 61 байгууллагад даатгалын үйлчилгээ үзүүлж байна. Манай байгууллага 2016 оны 1-р улиралд даатгалын туршлагатай олон улсын мэргэжилтнийг урьж холбогдох бүх ажилтнууд болон эрх баригч байгууллагын албан тушаалтнуудыг хамруулсан андеррайтинг, актуарын нэг долоо хоногийн сургалтыг зохион байгууллаа. Мөн оны 5-р сард олон улсын топ санхүүгийн даатгалын брокер болох Виллис Тoverc Ватсонтой / Willis Towers Watson /-той хамтран Санхүүгийн Даатгалын Форумыг Монгол улсад анх удаа амжилттай зохион байгууллаа. Бид Харилцагчийн үйлчилгээ, Нөхөн төлбөрийн шийдвэрлэлтэд өндөр ач холбогдогдол өгч, ялангуяа хурдан шуурхай үйлчилгээ буюу төлбөр тооцоог ажлын 3 хоногийн дотор гүйцэтгэж зах зээлдээ шилдэг нь байхыг зорьж ажиллаж байна. Тэнгэр Даатгалын хувьд нөхөн төлбөрийн зөвшөөрөл болон нөхөн төлбөрийн олголтын үйл ажиллагааны хяналт нь ил тод, шударга байх зарчимд тулгуурладаг. 2016 оны туршид компани нь хэд хэдэн олон улсын шагнал авсан билээ. Үүнээс дурьдвал: "International Finance" сэтгүүлээс Монгол улсын шилдэг даатгалын компани, "Global Banking & Finance Review"-ээс "Шилдэг Онлайн Даатгал"-ын компаниар тус тус нэрлэгдлээ.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

Компани нь 1.5 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллалаа. Энэ нь Монголын даатгалын зах зээлийн хувьд хамгийн өндөр үзүүлэлт юм.

“International Finance” сэтгүүлээс Тэнгэр Даатгалыг Монгол улсын шилдэг даатгалын компаниар, “Global Banking & Finance Review”-ээс “Шилдэг Онлайн Даатгал”-ын компаниар тус тус нэрлэгдлээ.

Тэнгэр Даатгал нь компанийн хүлээн зөвшөөрөх эрсдэлийг тогтоож андеррайтингийн бодлогоо шинэчиллээ.

Тэнгэр Даатгал нь Монгол улсын топ 100 компанийн нийт 61 аж ахуйн нэгжид даатгалын үйлчилгээ үзүүлж байна.


“International Finance” сэтгүүлээс Тэнгэр Даатгалыг Монгол улсын шилдэг даатгалын компаниар, “Global Banking & Finance Review”-ээс “Шилдэг Онлайн Даатгал”-ын компаниар тус тус нэрлэгдлээ.

Тэнгэр Даатгал нь Монголын Худалдаа Үйлдвэрийн Танхимтай хамтран Монгол улсад анх удаа Санхүүгийн Даатгалын Форумыг амжилттай зохион байгууллаа.

ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

Монгол Улсын төлбөрийн тэнцэл 2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оноос 249.9 сая ам.доллараар сайжирч, -18.2 сая ам.долларт хүрсэн бөгөөд үүний голлох шалтгаан нь урсгал тэнцлийн алдагдлын бууралт байна. Тодруулбал өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс хөрөнгө санхүүгийн дансны ашиг 58.0 сая ам.доллараар буурсан бол урсгал дансны алдагдал 412.0 сая ам.доллараар буурсан байна. Урсгал дансны алдагдлын бууралтын шалтгаан нь барааны дансны ашгийн өсөлт, орлогын дансны алдагдлын бууралттай холбоотой. Эдгээрийн нөлөөгөөр гадаад валютын улсын нөөцөд ирэх дарамт багасах юм.



ИНФЛЯЦИ

Улаанбаатар хотын инфляци 2014 оны 8 дугаар сараас эхлэн буурч 2016 оны 8 дугаар сарын байдлаар -0.6%-тай байгаа бөгөөд энэхүү дефляци нь 4 сар үргэлжилж байна. Инфляцийн бууралтын шалтгаан нь эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлаас үүдсэн нийт эрэлтийн бууралт байна. 2016 оны жилийн эцсийн байдлаар инфляци 0.5% байгаа бөгөөд 2017 онд 5% орчимд байхаар хүлээлттэй байна. Энэ нь зорилтот түвшнээс бага хэдий ч импортын барааны инфляци, нийлүүлэлтийн гаралтай инфляцийн (шатахуун, мах, гэх мэт) эрсдэл хэвээрээ байна.




Эх сурвалж: ХасBank

ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Гадаад, дотоод эдийн засгийн тааламжгүй нөхцөл байдлаас шалтгаалан 2013 оноос хойш огцом буурсан Монгол Улсад орох гадаадын шууд хөрөнгө оруулалт дорвитой сэргээгүйн зэрэгцээ томоохон компаниудын хөрөнгө оруулагчаас авсан зээлийн эргэн төлөлт хийгдэж хөрөнгө оруулалтын гарах урсгал нэмэгдсэнээр гадаадын шууд хөрөнгө оруулалт /цэвэр дүнгээр/ огцом буурч 2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр -4130.5 тэрбум ам.долларт хүрэв.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт




Эх сурвалж: Монгол Банк

ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН

2014 онд 7.8 хувь, 2015 онд 2.3 хувийн өсөлттэй байсан манай улсын эдийн засаг 2016 оны жилийн эцэст 1.0 хувийн өсөлттэй гарлаа.


Төлбөрийн тэнцлийн хүндрэлээс үүдсэн эдийн засгийн хүндрэл, удаашралын сөрөг нөлөөгөөр худалдааны салбар, нийт импорт агшиж, татварын суурь хумигдаж байгаатай холбоотойгоор бүтээгдэхүүний цэвэр татварын эдийн засгийн өсөлтөд оруулж буй хувь нэмэр улам бүр багасаж, улмаар сүүлийн 11 улирал дараалан сөрөг утгатай гараад байна.

Бодит ДНБ, дундаж таамаглал (%)



Эх сурвалж: Монгол Банк

Мөн Олон Улсын Валютын Сангийн судалгаанд дурдагдсан мэдээллээс үзвэл Монгол Улсын бодит ДНБ-ний өсөлт нь хөгжиж буй Азийн улсуудын ДНБ-ний өсөлттэй харьцуулахад савлагаа ихтэй байна. 2017 оны эхний хагаст ажилгүйдлын түвшин 9.4%-аас өсч 11-13% байх хүлээлттэй байна.




Эх сурвалж: ОУВС

3.5 МОНГОЛ УЛСЫН ГАДААД ВАЛЮТЫН АЛБАН НӨӨЦ

Монгол Улсын Гадаад валютын албан нөөцийн (ГВАН) хэмжээ 2016 оны 12 дугаар сарын байдлаар 1,296.3 сая ам.долларт хүрч өмнөх оноос 2.0 хувиар буюу 26.8 сая ам.доллараар буурчээ. ГВАН харьцангуй тогтвортой байгаа нь (i) иргэд, аж ахуйн нэгжүүдийн Монголбанкинд тушаасан алтны хэмжээ нэмэгдсэн, (ii) Монгол Улсад орох гадаад валютын урсгал нэмэгдсэнтэй холбоотой юм. 2016 оны эхний 12 сарын байдлаар Монголбанк иргэд, аж ахуйн нэгжээс 18.3 тонн алт худалдаж авсан. ГВАН-аар импортын хэрэгцээг хангах түвшин 4.9 сард хүрч өмнөх оны мөн үеэс ялимгүй бууралттай буюу 0.1 сараар буурсан үзүүлэлттэй байна.


Монгол Улсын Гадаад валютын албан нөөц



Эх сурвалж: Монгол Банк

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


Нийт хөрөнгө +22%




Хөрөнгө оруулалт +26%




Нөөц сан +13%




Цэвэр ашиг +265%




Нийт хураамжийн орлого +4%




Орлогд тооцсон хураамж -1%




Нөхөн төлбөр +16%




Үйл ажиллагааны зардал +6%



Нийт хураамжийн орлого /Бүтээгдэхүүнээр/



Нийт хураамжийн орлого /Борлуулалтын сувгаар/



ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тэнгэр Даатгал компанийн стратеги нь өргөн хүрээтэй бүтээгдэхүүнийг борлуулалтын олон суваг буюу өөрийн 19 салбар, арилжааны 9 банк, 13 брокер, 9 хамтран ажилладаг компани, 350 төлөөлөгчөөр дамжуулан бүх сегментийн харилцагч нарт хүргэхэд оршино. Даатгалын үйлчилгээний хэрэгцээ өдрөөс өдөрт өсч буй өнөө үед бид хүрэлцээ, хүртээмжтэй байдлаа сайжруулах үүднээс боломжит бүх борлуулалтын сувгаа ашиглан хувь хүн, аж ахуйн нэгжүүдэд үйлчилгээгээ хүргэж байна. Бид эдгээр борлуулалтын сувгаа ашиглан 62 мянган иргэн, 12 мянган аж ахуйн нэгжид үйлчилгээ хүргэсэн нь өмнөх тайлант жилээс 20% болон 11%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна.


Тайлант хугацаанд бид дараах зорилтод чиглэсэн. Үүнд:

- Шинэлэг, үр ашигтай байдлаар харилцагчдад илүү сайн үйлчилгээ үзүүлэх;
- Хөрөнгийн хувьд эдийн засгийн зорилтот өгөөжид хүрэх;
- Даатгалын шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх ;
- Хөрөнгө оруулалтыг идэвхтэй удирдах;
- Урт хугацааны өсөлтийн платформыг бий болгох, нутагшуулах.

Бид 100 гаруй байгууллагын харилцагчиддаа зориулан эрсдэлийн удирдлага, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны чиглэлээр сургалт зохион байгуулсан. Үйлдвэрлэл эрхлэгч компаниудын галын эрсдэлийг бууруулах үүднээс мэргэжлийн байгууллагатай хамтран галын эрсдэлийн судалгаа авч, сургалт зохион байгуулсан.

Тайлант хугацаанд бид олон улсын байгууллагаас зарласан нээлттэй тендерт амжилттай оролцож даатгалын үйлчилгээ үзүүлсэн. Мөн Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт зохиогдсон бүх томоохон үзэсгэлэн, хурал, үйл ажиллагаанд идэвхтэй оролцлоо. Монгол улсын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим болон олон улсын брокерийн компанитай хамтран анх удаа санхүүгийн даатгалын форумыг албан байгууллага, арилжааны банк, банк бус санхүүгийн байгууллага, олон улсын байгууллага, төрийн байгууллагуудад амжилттай зохион байгууллаа.

Тээврийн хэрэгслийн болон жолоочийн хариуцлагын даатгалыг хослуулсан даатгалын багц бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх үүднээс бид машины томоохон үзэсгэлэнд үндсэн ивээн тэтгэгчээр оролцсон. Тээврийн хэрэгслийн даатгалын бүтээгдэхүүн нь голчлон манай салбарууд болон банк, даатгалын зуучлагч, төлөөлөгч хамтран ажилладаг байгууллагууд зэрэг борлуулалтын сувгуудаар үзүүлдэг. Нөхөн төлбөр, үнэ, үйл ажиллагааны чадамжаа хөшүүрэг болгож онцлог бүтээгдэхүүнийг шинэлэг замаар харилцагчийн бүх сегментэд хүргэх нь манай стратеги юм.



Андеррайтеруудынхаа чадавхийг сайжруулах зорилгоор бид үл хөдлөх хөрөнгө, барилгын эрсдэл, гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлага, мэргэжлийн хариуцлага, эрүүл мэнд болон гэнэтийн осолын даатгал, банкны лоялти даатгалын бүтээгдэхүүн зэрэг чиглэлээр хэд хэдэн сургалт зохион байгуулсан.

Харилцагчдынхаа хэрэгцээ шаардлагад нийцүүлэх үүднээс гэрээний хариуцлага болон мэргэжлийн хариуцлагын даатгалыг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулж, зах зээлд нэвтрүүлсэн.

Банкны кредит карт эзэмшигчдэд зориулсан USD 50,000 хүртэлх хамгаалалттай дэлхийн бүх оронд хамрах боломжтой аялалын даатгалын бүтээгдэхүүнийг "А" зэрэглийн давхар даатгалын компанитай хамтран зах зээлд гаргалаа.

2016 оны 4-р сард малын индексжүүлсэн даатгалын 11-р цуврал эхэлсэн бөгөөд компанийн 10 салбар, 216 идэвхтэй агентууд мянга гаруй малчдаар дамжуулан 339 мянган малыг тус даатгалд хамруулж 181 сая төгрөгийн даатгалын цэвэр хураамжийн орлого хуримтлуулж чадлаа. Тэнгэр Даатгал нь цаг агаарын гамшигт үзэгдлийн нөхөн олговорт 52 сая төгрөгийг малчдад төлсөн билээ.



БОРЛУУЛАЛТЫН СУВАГ

Төв суурин газраас алслагдсан харилцагчиддаа тээврийн хэрэгсэл болон гэнэтийн ослын даатгалын хослуулсан багц бүтээгдэхүүн хүргэх үүднээс авто худалдааны төвд шинэ салбараа нээлээ. Хөрөнгө, хүнд машин механизм албан журмын даатгал, тээврийн хэрэгслийн хосолсон даатгал, малын даатгалын үйлчилгээг хүргэх үүднээс 6 брокер, 2 банк бус санхүүгийн байгууллага болон Үндэсний Хөрөнгө Оруулалтын Банктай хамтын ажиллагааны гэрээ шинээр байгууллаа. 2016 онд Тэнгэр Даатгал нь 109 иргэдийг даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох сургалтанд хамруулж тус иргэдийн 66 нь Санхүүгийн зохицуулах хорооноос даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрөл авсан.




ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Тэнгэр Даатгал ХХК нь зээлийн үнэлгээ, төлбөрийн чадвар, санхүүгийн чадамжид нь тулгуурлын давхар даатгалын компани болон давхар даатгалын брокеруудтай хамтран ажилладаг. Компани нь давхар даатгалын бодлого, стратегийн төлөвлөгөөнийхөө хүрээнд олон улсын үнэлгээний компаниуд болох Standard and Poor's, Moody's, Fitch, A.M.Best болон Санхүүгийн Зохицуулах Хорооны үнэлгээний дагуу дэлхийн түвшний давхар даатгалын компаниуд болон давхар даатгалын брокерийн компаниудтай үр дүнтэй хамтран ажиллаж байна. 2016 онд бид AIG (Singapore), Sirius International, Trust Re, QBE Australia, Zurich International Programs Hub Malaysia, Aviva (UK), Mai Reinsurance Brokers, Skala Reinsurance Brokers зэрэг давхар даатгал болон давхар даатгалын брокерийн компаниудтай түншлэлийг бий болгож, хамтран ажиллаа.




ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ



2016 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын даатгалын зах зээлд нийт 15 ердийн даатгалын компани, 1 амьдралын даатгалын компани ажиллаж байна. Тэнгэр Даатгал ХХК нь даатгалын зах зээлийн тэргүүлэгчдийн нэг юм.



Нийт хөрөнгийн хэмжээгээр зах зээлд 3 дугаарт буюу нийт зах зээлийн 10.0%-ийг эзэлжээ. Өөрийн хөрөнгийн хэмжээгээр 6.9 тэрбум төгрөгтэйгээр 2 дугаарт орсон байна.





Нийт хураамжийн орлогоор зах зээлд 6 дугаар байрт буюу нийт зах зээлийн 8%, цэвэр хураамжийн орлогоор 4 дүгээрт буюу зах зээлийн 9 хувийг эзэлж байна.



Эх сурвалж: Даатгагчдын холбооны статистик мэдээлэл, 2016

2016 онд бусад даатгалын компаниудаа манлайлан хамгийн их буюу 1.5 тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан байна. Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг мөн хамгийн үр өгөөжтэй буюу 22%-ийн өгөөжтэйгээр захиран зарцуулж ажилласан байна.

Тэнгэр Даатгал нь 2.4 тэрбум төгрөгийг нөхөн төлбөрт төлснөөр зах зээлд 7 байрт жагслаа. Нөхөн төлбөрийн дүн бага байна гэдэг нь андеррайтинг нь зохистой, даатгалын хураамж хангалттай, гадаад дотоод эрсдэлийн удирдлага нь нягт байгаагийн шинж юм.



Эх сурвалж: Даатгагчдын холбооны статистик мэдээлэл, 2016


ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ

Нөөцийг хангалттай бүрдүүлэх нь ирээдүйн өр төлбөр, түүнчлэн төлбөрийн чадварын харьцааг хангах нэг үзүүлэлт болох юм. Тэнгэр Даатгал нь 9 тэрбум орчим төгрөгийн нөөцийн сан бүрдүүлснээр дахин топ 3 компаний нэг болж чадлаа. Компани нь төлбөрийн чадварын харьцаагаа шаардагдах хэмжээнээс дээгүүр хадгалж 2016 оны туршид тасралтгүй нэмэгдүүлсээр оны эцэст 116.3 хувьд хүргэж чадлаа.




Эх сурвалж: Даатгагчдын холбооны статистик мэдээлэл, 2016


Хохирлын харьцаа



Зардлын харьцаа




Нийлмэл харьцаа




Эх сурвалж: Даатгагчдын холбооны статистик мэдээлэл, 2016

Тэнгэр Даатгалын хохирол, зардлын харьцаа нь тус тус 37%, 44% байгаа нь зах зээлд тэргүүлэгчидтэй харьцуулахад доогуур байна. Тиймээс эдгээрийн нийлмэл харьцаа буюу 81 хувийн харьцаа нь биднийг бүтээмж, үр ашигаараа тэргүүлэх зэрэгт байгааг илтгэх сайн үзүүлэлт юм.

Даатгалын салбарын Top-5 бүтээгдэхүүн, нийт хураамжид эзлэх хувиар



Тэнгэр Даатгалын Top-5 бүтээгдэхүүн, нийт хураамжид эзлэх хувиар



Дээрх графикт харуулсаны дагуу зах зээлийн хувьд гол салбар бол эд хөрөнгийн салбар юм. 2016 онд энэхүү салбарын нийт хураамж нь 31.8 тэрбум төгрөгт хүрсэн нь даатгалын зах зээлийн 28 хувийг эзлэж байна. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал болон тээврийн хэрэгслийн даатгал нь 27.8 болон 14.5 тэрбум төгрөгийн хураамж авчирсан нь зах зээлийн 25 болон 13 хувийг тус тус эзлэж байна. Дээр графикт тусгасан 5 бүтээгдэхүүний хэлбэр нь нийт хураамжийн 84 хувийг эзлэж байна.

Манай компанийн хураамжийн орлогын бүтэц нь мөн ийм дүр зурагтай байхаар байна. Тээврийн хэрэгслийн даатгал нь 2.3 тэрбум төгрөгийн хураамжийн орлого авчирсан нь компанийн нийт хураамжийн орлогын 25 хувийг эзлэж байхад эд хөрөнгө, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамжийн орлого нь 23, 21 хувийг тус тус эзлэж байна. Компанийн нийт хураамжийн орлогын 83 хувийн топ 5 даатгалын хэлбэр бүрдүүлж байна.

Үүнд: Тээврийн хэрэгсэл, Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, эд хөрөнгө, машин, хариуцлагын даатгал.

” ҮЙЛ АЖИЛЛАГААНД ГАРСАН ГОЛ ӨӨРЧЛӨЛТҮҮД

Тэнгэр Даатгал нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос гаргасан нягтлан бодох бүртгэлийн шинэ журамтай 2016 оны 1-р улиралд батгаан бүрэн нийцэж ажиллаж эхэллээ.

Энэхүү нягтлан бодох бүртгэлийн шинэ зарчмын дагуу даатгалын компанийн санхүүгийн тайлан Олон Улсын Санхүүгийн Тайлагналын стандартад илүүтэйгээр нийцэж, даатгалын нөөцийг зохистой хуваарилах болсон ба борлуулалтын шимтгэл зэрэг даатгалын хураамжтай холбоотой дансны бичилт нь холбогдох хугацаатайгаа уялдан тайлан балансд хүлээн зөвшөөрөгддөг болсон. Үүний зэрэгцээ бүртгэлийн эдгээр өөрчлөлттэй холбоотойгоор даатгалын үндсэн системээ сайжруулсан хувилбарт шилжүүлэв. Үүнд хураамж, авлагыг бүртгэн хүлээн зөвшөөрөх, хураамжийн орлого, давхар даатгал, нөхөн төлбөр, нөөцийг ангилах, гэрээ хэвлэх зэрэг даатгалын хэд хэдэн үндсэн модулыг сайжруулах, автоматжуулах ажиллагаанууд багтсан. Түүнчлэн, даатгалын үндсэн системийн шинэчилсэн хувилбар нь алслагдсан хөдөө орон нутгийн салбаруудад вебээр дамжуулан тус системд хандах боломжийг бүрдүүлсэн. Үүний үр дүнд, манай арын алба болон тэргүүн шугамын борлуулалтын үйл ажиллагаа үр ашигтай болоод зогсохгүй ажилтнуудын бүтээмж дээшилж, ажилтны тоо буурсан бөгөөд энэ нь манай харилцагч, хамтрагч нарт мөн үр өгөөжтэй алхам болсон. Агент, брокер зэрэг даатгалын зуучлагч нар одоо манай системд вебээр хандаж гэрээ хэвлэх, тайлан авах тал дээр илүү өргөн боломжтой болсон. Манай системээр шууд дамжуулан даатгалын гэрээг борлуулж буй хамтрагч байгууллагууд:

- Банк: ХасБанк, ҮХОБанк
- Брокер: Эрсдэлийн Шийдэл, Сүрэг Хараацай, Смарт Брокерс, Тод Капитал, Цагаан Гэрэлт
- Хамтрагч: Хас Лизинг

Үйл ажиллагааны бүтээмжийг дээшлүүлэх зорилтынхоо хүрээнд манай Мэдээлэл Технологийн баг нь МИИС буюу албан журмын даатгагчдын холбооны даатгалын систем дэх нөхөн төлбөрийн хэсэгтэй үндсэн системээ холбох, бусад зуучлагч байгууллагын борлуулсан даатгалын мэдээллийг системдээ нэгтгэх, албан бичиг баримт бүртгэл хөтлөлтийн систем, дотооддоо эрх зүйн бичиг баримт солилцох платформ нэвтрүүлэх зэрэг хэд хэдэн автоматжуулалтын шийдлийг амжилттай хэрэгжүүллээ.

2016 оны сүүлийн байдлаар бид Мэдээлэл Технологийн чиглэлээр доорх компаниудтай хамтран ажиллаж байна:

Infosoft LLC, IT Zone LLC, Trikom LLC, Mogul Service and Support LLC, MMA on MIIS, Softline LLC.

” IT SYSTEM FAILURES

2016 онд манай үндсэн систем 2 удаа удаан хугацаагаар тасалдаж зогссон:

1. Цахилгааны утсанд гэмтэл гарсны улмаас Төв Сервер 20 цаг зогссон. Үйл ажиллагааг 2 цагийн дотор буцаан сэргээсэн.
2. Үндсэн системийн шинэ хувилбарт шилжихтэй холбоотойгоор төв серверийг 4 цаг унтраах шаардлага гарсан. Датаг 2 цагийн дотор буцаан сэргээсэн.

» НӨХӨН ТӨЛБӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Даатгагч бүрийн үндсэн зорилго нь өөрийн харилцагчдаа болзошгүй эрсдэлээс үүдэх санхүүгийн алдагдлаас хамгаалахад оршдог тул бид нөхөн төлбөрийн шийдвэрлэлтийн дундаж хугацааг богиносгож 3.5 өдөр болгож чадсан үр дүнтэй ажиллалаа.

ОЛГОСОН НӨХӨН ТӨЛБӨР, ШИЙДВЭРЛЭЛТИЙН ХОНОГ /ТЭРБУМ ТӨГ/

ОН	ШИЙДВЭРИЙН ХОНОГ	ТОО	ДҮН /ТЭРБУМ/
2016	3.5	3524	2.4
2015	5.2	4507	2.8
2014	5.5	4143	2.6



Харилцагчдад 3,524 нэхэмжлэлийн дагуу нийт 2.4 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон бөгөөд хохирлын харьцаа нь 37% болсон байна.

Хүмүүсийн амьдралд урт хугацааны, эерэг нөлөө авчрахын тулд тогтсон стандартыг эвдэж харилцагчийн үйлчилгээнд эерэг өөрчлөлт авчрахыг зорьж ажилласныг бидний хүчин чармайлт, ажлын үр дүн харуулав.

Харилцагчиддаа нөхөн төлбөрийн явцыг цахим шуудангаар болон утсаар тухай бүр мэдээлж байгаа нь компанийн технологгоор танигдах зорилтын хүрээнд хийгдсэн үндсэн үйл ажиллагааны нэг хэсэг юм.

» ХҮНИЙ НӨӨЦ

Бид стратегийн түншлэл, хамтын ажиллагаагаараа дамжуулан өндөр бүтээмжтэй, өөр өөр чиглэлийн ажиллах хүчин сонгон шалгаруулж, хөгжүүлж байгаа бөгөөд Тэнгэр Даатгалыг Ажилтны Сонголт болгож байршуулах, байгууллага болон хувь хүний чадавхийг нэмэгдүүлэх үүднээс эрүүл, аюулгүй, үр бүтээлтэй ажлын орчин бүрдүүлэхэд чиглэж ажиллаж байна.



ИННОВАЦИД суурилсан ур чадвартай ажиллах хүч



Өрсөлдөхүйц цалин хөлс, ажилтныг дэмжсэн хөтөлбөр бүхий Хүний нөөцийн шилжилт хөдөлгөөний **ТОГТВОРТОЙ** байдал



СТРАТЕГИТ чиглэсэн байгууллагын бүтэц соёл



Үргэлжид хөгжин дэвжих хөтөлбөрүүд, **МЭРГЭЖЛИЙН** өсөлт




БҮТЭЭМЖТЭЙ, эрүүл ажиллах орчин, үр дүн






ХЭТИЙН ТӨЛӨВ


Нийт хөрөнгө




Нийт хураамж




Цэвэр ашиг




Нөөц сан



Нийт хураамжийн орлого /Бүтээгдэхүүнээр/



Нийт хураамжийн орлого /Борлуулалтын сувгаар/



Тэнгэр Даатгал нь харилцагч нартайгаа хамтран ажиллаж, төрөл бүрийн санааг дэмжиж, шинэ санаачлагад хөрөнгө оруулж, мэдээллийг ашиглан харилцагчиддаа илүү сайн үр дүн хүрэхэд туслах замаар айдасгүй ирээдүйг бий болгоход гол үүрэг гүйцэтгэсэн хэвээр байх болно. Бид харилцагч төвтэй хандлагатай тул 2017 оны уриаг: **"Таны амьдралын хором бүрийг аз жаргалтай байлгахын төлөө үргэлж хамтдаа!"** болгон зарласан. 2017 онд бид Тэнгэр Даатгалын дотоод үнэ цэнэ, тогвортой ашгийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулах үүднээс нийт хураамжаа 28% хувиар өсгөж, бага зардал, өндөр бүтээмжтэй ажилтнуудаараа дамжуулан технологийн дэд бүтэц, онлайн даатгалын шинэ платформоо сайжруулахаар зорьж ажиллана.

Байгууллагын болон Хэрэглэгчийн тэргүүлэх чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон.

Үүнд:

БАЙГУУЛЛАГА	ИРГЭД
<ul style="list-style-type: none"> • Илүү харилцагч төвтэй соёл бий болгох • Үр ашигтай андеррайтингийн шийдвэр гаргахад өөрсдийгөө сорих • Шууд борлуулалтаа нэмэгдүүлж шилдэг 100 аж ахуйн нэгжийн 60-д нь хүрэх • Санхүүгийн үйлчилгээний салбар эхний сонголт байх • Эрүүл мэнд болон Аялалын даатгалыг болгоомжтойгоор нэмэгдүүлэх • Гүйцэтгэлийн удирдлага болон ажилтны хөгжлийн төлөвлөгөө 	<ul style="list-style-type: none"> • Харилцагч төвтэй байгууллага • Багийн ажиллагаатай соёл, бүтээмж нэмэгдүүлэх, харилцагчийг таних, шинэ санаачлага • Тээврийн хэрэгслийн даатгал, моргейжийн даатгалын хүрээнд шилдэг харилцагчийн туршлагыг нийт харилцагчдад түгээх • Бизнесийн загвараа сайжруулах (жишээ нь онлайн, мобайл, өөрөө өөртөө үйлчилэх гэх мэт) • Банкаар дамжуулсан даатгалын салбарт үнэмлэхүй тэргүүлэгч болох • Гүйцэтгэлийн удирдлага болон ажилтны амлалтын төлөвлөгөө

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Дотоод хяналтын функц нь бүх газар хэлтсийн үүрэгт тусгагдсанаас гадна хяналтын гол нэгж болох Дотоод аудитор нь Төлөөлөн Удирдах Зөвлөл (ГУЗ)-д ажлаа шууд тайлагнаж байна. Өнгөрсөн онд хүний нөөц болон санхүүгийн 2013 оноос 2016 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийгдсэн.

2011 оноос 2015 оны тайланд дүүргийн татварын хэлтэс, 2015 болон 2016 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд Санхүүгийн Зохицуулах Хороо хяналт шалгалт хийсэн. Шалгалтын үр дүнд нөхөн төлбөр, давхар даатгал, санхүү, хүний нөөцийн үйл ажиллагаагаа илүү сайжруулж чадлаа.

■ ТЭНГЭР ДААТГАЛ ХХК НЬ 2016 ОНД ТАВАН ЧУХАЛ ЧИГЛЭЛИЙН ДОТООД ЖУРМАА ОЛОН УЛСЫН ТҮВШИНД НИЙЦҮҮЛЭН САЙЖРУУЛСАН.

Андеррайтерийн ажил үүрэг, ажилын зааварчилгааг тодорхой тусгаж, борлуулалтын ажилтнаас ялгаж өгснөөрөө Тэнгэр Даатгалын андеррайтингийн шинэчлэгдсэн бодлого нь олон улсын андеррайтингийн үйл ажиллагаатай нэг алхмаар ойртсон. Ялангуяа андеррайтерууд нь харилцагчид хамгийн тохиромжтой даатгалын хамгаалалтыг тусгайлан санал болгох үүднээс боломжит харилцагчийн үйл ажиллагааны судалгаа, эрсдэлийн үнэлгээг хийж эхэлсэн. Энэ нь боломжит харилцагч даатгах боломжгүй эрсдэлийг даатгах хүсэлт гаргасан тохиолдолд мөн хэрэгтэй байдаг. Ийм нөхцөлд хоёр талд харилцан ашигтай, оновчтой шийдвэр гаргахад андеррайтерийн чадвар, туршлага чухал байдаг.

Даатгалын хураамжийг хэсэгчлэн төлүүлэх нь харилцагчаа халамжилж буйн нэг илрэл юм. Гэсэн хэдий ч зарим үед хугацаа хэтэрсэн төлбөр нь даатгалын хамгаалалтыг цуцална гэсэн үг бөгөөд нөхөн төлбөр гарахад энэ нь асуудал болдог. Бид харилцагчтайгаа харилцахдаа энэхүү алдааг гаргаж байснаа олж илрүүлсэн. Хуваарийн дагуу хэсэгчилсэн төлөлт болон хугацаа хэтэрсэн төлөлттэй ирсэн үед үл ойлголцол гаргахгүй байж, харилцагчийн үйлчилгээгээ сайжруулах үүднээс бид авах арга хэмжээг алхам алхмаар тодорхойлсон.

Эрсдэлийн удирдлагын зүгээс хийсэн дээрх сайжруулалтын хүрээнд андеррайтерууд журмын дагуу хэсэгчилсэн төлөлтийн талаар тогтмол тайлагнаж холбогдох даатгалын хэлбэрийн багцын эрсдэлийн зэрэг, ашигт байдалд байнгын хяналт тавьж ажиллаж байна. Эрсдэлийн удирдлагын шинэчлэгдсэн журам нь мөн хянах шаардлагатай эрсдэлийг тодорхойлох бөгөөд үүний хүрээнд андеррайтер нь даатгалын бүх шугам болон бүтээгдэхүүний хүлээн зөвшөөрөх эрсдэлийг гаргаж ирэх юм.

Даатгалын хувьд харилцагчид нөхөн төлбөр гарах үед манай үйлчилгээнд үнэлгээ өгдөг. Тиймээс нөхөн төлбөрийн үйлчилгээний үед харилцагчаа халамжлах нь борлуулалтын үед халамжлахаас илүү чухал юм. Үүнтэй холбоотойгоор нөхөн төлбөрийн журамд харилцагчийн гомдлын талаар тусгайлсан хэсэг оруулж, гомдол гарсан тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой тусгасан.

Манай үйл ажиллагаа бүрэн автомат болсон ба ажилтнууд хаанаас ч хандаж болох даатгалын цогц програм хангамжтай зах зээл дээрх хоёр даатгалын компанийн нэг учраас үйл ажиллагааны нэгэн чухал хэсэг бол мэдээллийн технологи юм. Програмын аюулгүй байдал, онцгой байдлын нөөц төлөвлөгөө бидэнд маш чухал учраас мэдээллийн технологийн бодлогод онцгой байдлын нөөцийн төлөвлөгөөний журам, датабаазын журам, програм хангамж хөгжүүлэлт, засварын журам, социал медиа хэрэглэгчийн журам, цахим шуудангийн журмуудыг тус тус багтаасан. 2016 оны эхээр Санхүүгийн Зохицуулах Хорооноос нягтлан бодох бүртгэлийн шинэ стандартыг баталсан. Шинэ стандартын дагуу нягтлан бодох бүртгэлийн дотоод журмаа шинэчлэх ажлыг хэрэгжүүлэхэд Тэнгэр Даатгал анхдагч байж чадсан.

» ДОТООД ХЯНАЛТ

Эрсдэл хүлээх гэдэг нь аж ахуйн нэгжийн шинж чанарын салшгүй нэг хэсэг юм. Зохион байгуулалттай эрсдэлийн удирдлагын процесс нь компанийн удирдлагыг хяналттайгаар эрсдэл хүлэх боломж олгодог. Тэнгэр Даатгалын бизнесийн үйл ажиллагааны зураглалыг цогцоор нь авч үзэхийн тулд эрсдэл болон боломжийг дээрээс доош (top-down), доороос дээш (bottom-up) аргыг ашиглан системтэйгээр тодорхойлсон. Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны хүрээнд бид өдөр тутмын үйл ажиллагаанд нөлөөлж болох эрсдэл, түүнийг хэмжих хэмжүүрийг тодорхойлж, эдгээр эрсдэлийг тогтмол хянаж тайлагнах үүднээс хүлээн зөвшөөрөх түвшинг тогтоосон. Холбогдох бүх эрсдэл болон боломжуудыг тоон болон чанарын үзүүлэлтийг харгалзан үр нөлөө, магадлалаар нь эрэмбэлсэн бөгөөд үүнийгээ сар тутам удирдлагуудад тайлагнаж байна.

Эрсдэлийн хүрээнд бид дараах ангиллын эрсдэлийг авч үздэг:



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

» ХОЛБОГДОХ ЭТГЭЭДИЙН ГҮЙЛГЭЭ


Тэнгэр Даатгал нь толгой компани болох Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК, түүний бусад охин компаниуд болох ХасБанк, Хас Лизинг, Хас Секюритигээр гүйлгээ хийдэг.

ХОЛБОГДОХ ЭТГЭЭДИЙН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	ДҮН /ТӨГРӨГ/
Орлого	446,738,628
Зардал	479,513,414

» НООГДОЛ АШИГ ТҮҮНИЙГ ХУВААРИЛАХ БОДЛОГО

Хуримтлагдсан ашгийг хөндлөнгийн аудитар буюу одоогоор Делойт Онч Аудит ХХК-аар шалгагдсаны дараа Компанийн хувьцаа эзэмшигчид ноогдол ашгийн хуваарилалтыг зарлах эрхтэй. 2016 онд ноогдол ашиг хуваарилаагүй.

КОМПАНИЙН



Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК (хувьцаа эзэмшигч) нь 2013 оноос хойш Тэнгэр Даатгал ХХК-ийн (Компани) цорын ганц хувьцаа эзэмшигч бөгөөд компанийн удирдлага нь бизнесийн өсөлтийг дэмжих үүднээс сайн засаглалын бүтэцийг бий болгож, шаардлагатай үед өөрийн бүтцээ өөрчлөн, сайжруулахаар зорин ажиллаж байна.

Тэнгэр Даатгал нь Монгол улсын санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч тэргүүлэгч группын нэг, банк санхүүгийн үйлчилгээ явуулдаг Тэнгэр Санхүүгийн Нэгдэлийн бүрэн эзэмшлийн охин компани юм. Тэнгэр Санхүүгийн Нэгдлийн дийлэнх хувийг хүлээн зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулагчид эзэлдэг.

Тэнгэр Санхүүгийн Нэгдэлийн хувьцаа эзэмшигчид нь олон улсын томоохон санхүүгийн байгууллагууд, дотоод болон гадаадын нэр хүндтэй компаниуд, хөрөнгө оруулалтын сангаас бүрддэг. Монгол улсад өөр ямар ч банк, санхүүгийн салбарын компани ийм олон төрлийн хувьцаа эзэмшигчдийн бүтэцтэй байхгүй. Энэ нь манай өрсөлдөх давуу тал бөгөөд хувьцаа эзэмшигчдийн мэдлэг, хөрөнгө, сүлжээ нь манай банкны бизнесийг өргөжүүлэх нэг хөшүүрэг болж байна.

БҮТЭЦ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



Магваны БОЛДОО

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Дарга

М.Болд нь 2014 оны 7 сарын 10-наас ХасБанкны Гүйцэтгэх Захирлаар томилогдон ажиллаж байгаа бөгөөд ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-н гүйцэтгэх болон ХасБанкны ТУЗ-ийн гүйцэтгэх бус гишүүн, 2011 оноос ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. ТэнГэр Санхүүгийн Нэгдлээс өмнө ХасБанкны Гүйцэтгэх захирлаар 2 жил, Ерөнхийлөгчөөр 3 жил ажиллажээ. М.Болд нь төрийн болон хувийн хэвшлийн банк, санхүүгийн байгууллагууд, мөн түүнчлэн Дэлхийн Банк, Олон улсын

валютын сан зэрэг олон улсын санхүүгийн байгууллагад хорь гаруй жил ажиллаж, банкны салбарын эдийн засгийн бодлого, бүтцийн шинэчлэлийн асуудлаар гүнзгий мэргэшсэн юм. Тэрбээр 1996-2000 онд Монгол Банк (Төв Банк)-ны дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байлаа. Мөн Зах зээл судлалын хүрээлэнд дэд захирал, Монголын Экспорт Импортын Банкны Гүйцэтгэх Захирал, ОХУ-ын Москва дахь Олон Улсын Хөрөнгө Оруулалтын Банк болон Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Банкны ТУЗ-ийн гишүүн, Афганистан Улсын Төв Банкинд зөвлөх, Монголын Банкуудын Холбооны Дэд Ерөнхийлөгчөөр тус тус ажиллаж байв. М. Болд нь БНУУ-ын Будапешт хотын Эдийн Засгийн Их Сургуулийг Олон улсын эдийн засагч мэргэжлээр төгссөн бөгөөд АНУ-ын Колумбийн Их сургуульд эдийн засгийн бодлого, удирдлагын чиглэлээр олон улсын харилцааны магистрын зэрэг хамгаалжээ. Тэрбээр Зээлийн Мэдээллийн Сан ХХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллахаас гадна 2011 оны 12-р сараас эхлэн Монголын Банкуудын Холбооны ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаж байна. М. Болд нь Бүгд Найрамдах Исланд улсын Өргөмжит Консул.



Ганибалын АМАРТУВШИН

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн

Г. Цэвэгжав нь 2013 оны 5 дугаар сараас ХасЛизинг ХХК-ийн гүйцэтгэх захиралаар томилогдон ажиллаж байна. Өмнө нь Тэнгэр Санхүүгийн Нэгдэлийн санхүү эрхэлсэн захирлаар, ХасБанкны санхүү эрхэлсэн захирлаар ажиллаж байсан туршлагатай. Өмнө нь Америкийн Сан Франциско хот дахь олон төрлийн брэндийн тавилгын компанид, хөрөнгө зохицуулалтын менежерээр ажиллаж байсан. Рэстор Хардвэр компанид ажиллаж байх хугацаандаа

тус компанийн хөрөнгийн зохицуулалт, эрсдэлийн удирдлагын чиглэлээр, Сан Франциско хотод байрладаг БлүФин Ассошиэт хэмээх компьютерийн програм хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компанид, Дэнвэр хотод байрлах Вагнер брэндийн тоног төхөөрөмжийн компанид олон улсын нягтлан бодогч болон хөрөнгө зохицуулалтын шинжээчээр ажиллаж байгаад бизнесийн удирдлагаар суралцаж эхэлсэн. АНУ-ын Колорадогийн Их Сургуулийг олон улсын бизнес ба мэдээллийн системийн удирдлагын бакалавр, Рэгис Их Сургуулийг Санхүү, Нягтлан Бодох Бүртгэлийн MBA зэрэгтэй төгссөн.



Гүмэнжавын ЦЭВЭГЖАВ

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн

Г. Цэвэгжав нь 2013 оны 5 дугаар сараас ХасЛизинг ХХК-ийн гүйцэтгэх захиралаар томилогдон ажиллаж байна. Өмнө нь Тэнгэр Санхүүгийн Нэгдэлийн санхүү эрхэлсэн захирлаар, ХасБанкны санхүү эрхэлсэн захирлаар ажиллаж байсан туршлагатай. Өмнө нь Америкийн Сан Франциско хот дахь олон төрлийн брэндийн тавилгын компанид, хөрөнгө зохицуулалтын менежерээр ажиллаж байсан. Рэстор Хардвэр компанид ажиллаж байх хугацаандаа тус компанийн хөрөнгийн зохицуулалт, эрсдэлийн удирдлагын чиглэлээр, Сан Франциско хотод байрладаг БлүФин Ассошиэт хэмээх компьютерийн програм хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компанид, Дэнвэр хотод байрлах Вагнер брэндийн тоног төхөөрөмжийн компанид олон улсын нягтлан бодогч болон хөрөнгө зохицуулалтын шинжээчээр ажиллаж байгаад бизнесийн удирдлагаар суралцаж эхэлсэн. АНУ-ын Колорадогийн Их Сургуулийг олон улсын бизнес ба мэдээллийн системийн удирдлагын бакалавр, Рэгис Их Сургуулийг Санхүү, Нягтлан Бодох Бүртгэлийн MBA зэрэгтэй төгссөн.



Пэрэнлэйн ЭРДЭНЭЖАРГАЛ

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүн

П.Эрдэнэжаргал нь 2005 оноос ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК болон "ХасБанк"-ны ТУЗ-ийн гүйцэтгэх бус гишүүн, 2004 оноос Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн Гүйцэтгэх Захирлаар ажиллаж байна. 1982-1988 онд Хөдөлмөр, нийгэм хангамжийн улсын хороонд хөдөлмөрийн эдийн засагч, 1988-1991 онд Сайд нарын зөвлөлийн дэргэдэх Удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх институтэд багш, 1991-1992 онд Засгийн газрын Төрийн бодлого, нийгмийн асуудлыг судлах төвд мэргэжилтэн, хэлтсийн дарга, 1992-1997 онд Монголын хөгжлийн хүрээлэнгийн гүйцэтгэх захирлаар тус тус ажиллаж байв. 1997-2004 онд Монголын нээлттэй нийгэм хүрээлэн (Соросын Сан)-гийн дэд захирал, боловсрол, хэвлэл мэдээлэл, эрүүл мэндийн салбарын хөтөлбөр хариуцсан захирлаар тус тус ажилласан. Тэр шийдвэр гаргалтанд иргэдийн оролцоог хангах судалгааны чиглэлээр мэргэшиж, энэ чиглэлийн үйл ажиллагаанд өмгөөлөл хийн идэвхтэй оролцож байна. ОХУ-ын Ростов-на-Дону хотын Улсын Их Сургуулийг 1982 онд сэтгэл зүйч мэргэжлээр төгссөн.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



Мацуока Ёшиаки

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн

М.Ёшиаки нь 1991 онд Орикс корпорациас ажлын гараагаа эхэлсэн. Тэрбээр одоогоор Орикс корпорацийн ерөнхий захирлын хариуцлагатай албыг хашиж байна. М.Ёшиаки нь тасралтгүй арван дөрвөн жилийн туршид санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр ажиллаж туршлага хуримтлуулсан. Тэрбээр 1991 онд Япон улсын Квансей Гакун их сургуулийг Бакалавр зэрэгтэй төгссөн.



ОЙБЕК Н. Халилов

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн

“Тэнгэр Даатгал” ХХК-ийн Гүйцэтгэх захирал ноён Ойбек Н. Халилов тус албан тушаалд 2015 оны 9 сарын 15-ны өдрөөс эхлэн ажиллаж байна. Тэрбээр ажиллын гараагаа 1994 оноос олон улсын нэр хүнд бүхий AIG (American International Group) группт тасралтгүй 20 гаруй жилийн хугацаанд Төв ази, Кавказын орнууд болох Узбекистан, Казакстан, Азербайджан болон Гүрж улсыг хариуцсан захирлын албан тушаалд ажиллаж байсан.

Ойбек Н. Халилов AmCham- Америкийн худалдааны танхимын Монгол дахь төлөөлөгчийн газар Хас Банкыг төлөөлөн гишүүнээр томилогдсон. Тэрбээр 1997 оноос AmCham- Америкийн худалдааны танхимын төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, Дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байжээ. Ойбек Н. Халилов нь Ташкентын Эдийн Засгийн Их Сургуулийн Санхүүгийн чиглэлээр бакалаврын зэрэг хамгаалсан байна.

2016 ОНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ

2016 онд нийт 17 ТУЗ-ын хурал зохион байгуулагдсан бөгөөд дөрөв нь хуваарьт буюу энгийн хурал, нэг нь хуваарьт бус хурал, арван хоёр нь хөндлөнгөөс онлайн-аар санал өгсөн хурал байлаа. Доорх хүснэгтээс илүү дэлгэрэнгүй мэдээллийг харж болно.

2016 онд зарласан энгийн буюу хуваарьт хурлын ТУЗ-ын гишүүдийг ирц (биечлэн/санал хураалт):

№	Нэр	Хурал:	2016-4-16	2016-4-21	2016-6-20	2016-10-5	2016-12-19	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн ирц
			(Y1)	(Y1)	(Y2)	(Y3)	(Y4)	
1	Магван БОЛДОО		Ү	Т	Т	Т	Т	80%
2	Ганибал АМАРТҮВШИН		Т	Т	Т	Т	Т	100%
3	Гүмэнжав ЦЭВЭГЖАВ		Т	Т	Т	Т	Ц	100%
4	Буянжаргал ДЭЛГЭРЖАРГАЛ		Т	-		Ү		50%
5	Пэрэнлэй ЭРДЭНЭЖАРГАЛ		-	-	Т	Т	Ц	60%
6	Мацуока Ёшиаки		-	-	Т	-	Ц	50%
ТУЗ-ын хурлын ирц			80%	50%	100%	80%	100%	

2016 ОНД ГАРГАСАН ТУЗ-ЫН ШИЙДВЭРИЙН ОНЦЛОХ

Компанийн удирдлагаас 2016 онд нийт 40 асуудал ТУЗ-д мэдээлэл, хэлэлцүүлсэнээс 21 нь ТУЗ-ын шийдвэрээр батлагдсан.

Компанийн дотоод хяналтыг сайжруулах, зохистой засаглалыг бий болгох үүднээс өмнө нь буюу 2015 оны 3-р сарын 23-ны өдөр ТУЗ-ын No#15/003-р тушаалаар Эрсдэлийн Удирдлагын Журмыг баталсан бөгөөд тус тушаалаар компанийн удирдлагын багт 25 сая хүртэлх даатгалын нөхөн төлбөр шийдвэрлэж олгох эрх, 6.1-р зүйлд заасны дагуу 5 сая төгрөг хүртэлх сангаас хаах эрх олгож байсан.

ТУЗ-ын гишүүд Эрсдэлийн Удирдлагын Журмыг эргэн харж, даатгалын нөхөн төлбөр шийдвэрлэж олгох эрхийг жилд 3 тэрбум хүртэл, сангаас хаах эрхийг 25 сая төгрөг хүртэл болгон тус тус нэмэгдүүлсэн. Компанийн удирдлага энэхүү өөрчлөлт нь даатгалын нөхөн төлбөрийн шийдвэрлэлтийг хурдасгах, цаг алдахгүй ажиллах нэг боломж гэж харж байна.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



10 дахь удаагаа зохион байгуулагдсаж буй хөлбөмбөгийн “Дуулиан 2020” тэмцээнд 84-р сургуулийн өсвөрийн шигшээ багыг ивээн тэтгэж амжилттай оролцуулав. тэмцээнд оролцсон бүх 48 сурагч тамирчдынхаа гэнэтийн ослийн даатгалыг Тэнгэр Даатгал ХХК бүрэн хариуцсан.



Бид Хөгжлийн Алтан Сан Холбоотой хамтран Монгол улсын залуу үед санхүүгийн боловсрол олгох, үндэсний хэмжээнд сургалтын хөтөлбөр боловсруулах, ажлын хэсэгт орж ажилласан. Санхүүгийн боловсролын үндэсний хөтөлбөр нь ерөнхий боловсролын сургуулийн боловсролын хөтөлбөрийн хүрээнд албан ёсоор орсон. Энэ бүх хүчин чармайлтын үр дүнд 2016-2017 оны хичээлийн жилд орон даяар 23,000 сурагчид санхүүгийн боловсрол олгох хичээлд хамрагдлаа.



Хас Төгөл аяны хүрээнд Тэнгэр Даатгал болон Тэнгэр Санхүүгийн Нэгдлийн охин компаниуд Улаанбаатар хот болон 21 аймгуудад нийт 39,000 мод, 30 төгөл тарьж байгууллаа.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Тэнгэр Даатгал ХХК-ийн Хувьцаа эзэмшигч танаа,

Бид Тэнгэр Даатгал ХХК (цаашид “Компани” гэх) -ийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн иж бүрэн орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг

Удирдлага нь санхүүгийн тайлангаа Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэн шударгаар илэрхийлэх, эдгээр санхүүгийн тайланг алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг хэмжээний зөрчилгүйгээр бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэж тогтоосон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Аудиторын үүрэг

Аудитор хийсэн аудитдаа үндэслэн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүрэгтэй. Бид аудитаа Аудитын Олон Улсын стандартын дагуу гүйцэтгэсэн болно. Санхүүгийн тайлан нь материаллаг үзүүлэлтийнхээ хувьд алдаа зөрчилгүй гэдэг зохих магадлагаа олж авахуйцаар аудитыг төлөвлөж гүйцэтгэх ба ёс зүйн шаардлагуудыг дагаж мөрдөхийг эдгээр стандартуудад шаарддаг.

Аудит нь санхүүгийн тайлан дахь дүн болон тодруулгыг нотлох нотолгооны зүйлсийг олж авахын тулд гүйцэтгэдэг аудитын горимуудаас бүрдэнэ. Санхүүгийн тайлан алдаа болон санаатай зальт үйлдлийн улмаас материаллагаар зөрчилтэй илэрхийлэгдэх эрсдэлд өгсөн аудиторын үнэлгээнээс хамааран аудитын горимуудыг сонгодог. Аудитор эрсдэлийн үнэлгээ хийхдээ санхүүгийн тайлан бэлтгэх шударгаар тайлагнахад хэрэглэдэг дотоод хяналтыг судалдаг. Энэ нь зөвхөн тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимуудыг сонгохтой холбоотой бөгөөд аж ахуйн нэгжийн дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт өгөх зорилгогүй болно. Үүнээс гадна аудит нь удирдлагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой эсэх, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлийн урьдчилсан тооцоолол зохистой эсэх, санхүүгийн тайлангийн ерөнхий тайлагналын байдлыг үнэлэх ажлуудаас бүрддэг.

Бидний олж авсан аудитын нотлох зүйлс нь аудиторын дүгнэлт гаргах хангалттай ба зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Дүгнэлт

Бид, Компанийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн, шударгаар илэрхийлж байна гэж дүгнэж байна.

Хэрэглээний хязгаарлалт

Энэхүү тайлан нь хувьцаа эзэмшигчдийн хүсэлтийн дагуу зөвхөн Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан ба аливаа нэгэн өөр зорилго агуулаагүй болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бусад этгээдийн өмнө үүрэг хариуцлага хүлээхгүй болно.

Шагдарсүрэнгийн Норжинбат

Захирал, МНБ

Делоитт Онч Аудит ХХК 2016 оны

3 дугаар сарын 24



ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2015 ОНЫ 12 САРЫН 31
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

	2016	2015
ХӨРӨНГӨ		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,260,245	1,184,236
Богино хугацаат хадгаламж ба засгийн газрын бонд	11,179,003	8,854,415
Дансны ба бусад авлага	1,178,094	799,846
Даатгалын гэрээний хойшлогдсон зардал	455,107	499,565
Давхар даатгагчийн орлогод тооцоогүй нөөц	1,341,150	992,233
Урьдчилж төлсөн зардал	60,444	99,421
Бараа материал	76,684	53,511
Хойшлогдсон татварын хөрөнгө	4,812	-
Үндсэн хөрөнгө	1,092,876	1,194,449
Биет бус хөрөнгө	5,259	3,557
Нийт хөрөнгө	16,653,674	13,681,233
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Даатгалын гэрээний нөөц сангууд	8,877,018	7,845,546
Дансны ба бусад өглөг	888,146	1,202,864
Орлогын албан татварын өглөг	17,580	16,038
Нийт өр төлбөр	9,782,744	9,064,448
Эздийн өмч		
Энгийн хувьцаа	4,250,000	3,500,000
Нэмж төлөгдсөн капитал	130,000	130,000
Хуримтлагдсан ашиг	2,490,930	986,785
Нийт өр төлбөр ба эздийн өмч	16,653,674	13,681,233

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
ИЖ БҮРЭН ОРЛОГЫН ТАЙЛАН
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2015 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

	2016	2015
Орлогод тооцсон цэвэр хураамж		
Даатгалын нийт орлогод тооцсон хураамж	8,336,465	8,187,281
Давхар даатгагчид ногдох хураамж	(2,002,950)	(1,781,154)
Орлогод тооцсон цэвэр хураамж	6,333,515	6,406,127
Нөхөн төлбөрийн зардал, цэвэр дүнгээр		
Нөхөн төлбөрийн зардал	(2,934,651)	(3,467,663)
Давхар даатгагчид ногдох нөхөн төлбөр	38,529	86,964
Нөхөн төлбөрийн зардал	(2,896,122)	(3,380,699)
Даатгалын үйл ажиллагааны цэвэр орлого	3,437,393	3,025,428
Санхүүгийн ба бусад орлого	1,964,547	1,522,088
Бусад олз ба (гарз)	39,432	(10,370)
Ерөнхий ба удирдлагын зардал	(3,751,984)	(3,996,556)
Татварын өмнөх ашиг	1,689,388	540,590
Орлогын татварын зардал	(185,243)	(128,401)
Цэвэр ашиг	1,504,145	412,189
Бусад иж бүрэн орлого	-	-
Нийт иж бүрэн орлого	1,504,145	412,189

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
 МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
 12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2015 ОН
 (МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

	2016	2015
Цэвэр ашиг	1,504,145	412,189
Тохируурлгууд:		
Орлогын татварын зардал	185,243	128,401
Хүүгийн орлого	(1,705,613)	(1,319,859)
Элэгдэл ба хорогдлын зардал	134,355	130,810
Найдваргүй авлагын зардал	83,852	48,875
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	18,965	7,076
Гадаад валютын ханшийн зөрүүгийн хэрэгжээгүй гарз/(олз)	7,053	(1,496)
	228,000	(594,004)
Ажлын капиталын өөрчлөлт:		
Дансны ба бусад авлага	1,431	478,636
Бараа материал	(23,173)	22,573
Урьдчилж төлсөн зардал	38,977	(12,309)
Даатгалын гэрээний хойшлогдсон зардал	44,458	34,201
Орлогод тооцоогүй хураамжийн нөөц	(348,917)	(168,104)
Даатгалын гэрээний нөөц сангууд	1,031,472	851,454
Дансны ба бусад өглөг	390,689	(278,235)
	1,362,937	334,212
Төлсөн орлогын татвар	(188,513)	(128,831)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	1,174,424	205,381
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Хүлээж авсан хүүгийн орлого	1,233,352	1,235,380
Худалдан авсан үндсэн хөрөнгө	(49,700)	(127,791)
Үндсэн хөрөнгө борлуулснаас хүлээж авсан мөнгө	151	4,497
Худалдан авсан биет бус хөрөнгө	(3,900)	(4,400)
Хугацаат хадгаламж	58,282	(1,856,461)
Худалдан авсан засгийн газрын бонд	(2,494,454)	(1,015,610)
Засгийн газрын бонд борлуулснаас хүлээж авсан мөнгө	150,000	1,210,900
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(1,106,269)	(553,485)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Холбоотой талаас авсан санхүүжилт	-	750,000
Хувьцаа эзэмшигчдэд төлсөн ногдол ашиг	-	(166,667)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-	583,333
Мөнгөний үлдэгдэл дэх ханшийн зөрүүгийн нөлөөлөл	7,854	793
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн өсөлт	76,009	236,022
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,184,236	948,214
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,260,245	1,184,236

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН 2015 ОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

	Энгийн хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан ашиг	Нийт эздийн өмч
2015 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	3,500,000	130,000	741,263	4,371,263
Тайлант жилийн нийт иж бүрэн орлого	-	-	412,189	412,189
Зарласан ногдол ашиг	-	-	(166,667)	(166,667)
2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	3,500,000	130,000	986,785	4,616,785
Тайлант жилийн нийт иж бүрэн орлого	-	-	1,504,145	1,504,145
Гаргасан хувьцаа	750,000	-	-	750,000
2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	4,250,000	130,000	2,490,930	6,870,930

ХАРИЛЦАГЧДЫН СЭТГЭГДЭЛ



Долгорсүрэн:

“Тэнгэр даатгалаас зөвлөгөө аван хамтран ажилладаг тань талархаж байна.”

... Манай компани ноос, ноолуурын салбарт 20 гаран жил амжилттай яваа, өөрийн гэсэн брэнд бүтээгдэхүүн бүхий компани билээ. Салбартаа томоохон байр суурь эзэлдэгийн хувьд хэрэглэгчдийнхээ эрэлтийг дээдлэн Улаанбаатар хотод 8, хөдөө орон нутагт 10 салбар дэлгүүр байгуулан ажиллаж байна.

Амжилттай ажиллахын хажуугаар саад бэрхшээл эрсдэл гэж байдаг. Гэхдээ энэ нь хэлж биш гэнэт гарч ирдэг нь их аюул дагуулдаг. Тухайлбал, бид дэлгүүртээ бараа бүтээгдэхүүнийг хэрэглэгчийнхээ

ая тухад зориулан аль тавиур, лангуунаас авч үзэх, өмсөх зэрэг бүх бололцоогоор нь хангасан байдаг. Мөн бид эрсдэлийг тооцон хяналтын камер байршуулах, худалдааны менежерээ сургах зэрэг арга хэмжээ авч ажилладаг ч зарим иргэдийн болчимгүй үйлдлээс болж компани бараа бүтээгдэхүүний дутагдалд орох эрсдэл байсаар байна. Гэвч бид энэ эрсдэлээс гарах зөв гарц бол даатгалд хамрагдах гэж үзээд Тэнгэр даатгалын бараа материалын даатгалын гэрээ байгуулаад бөгөөд 3 дахь жилдээ аливаа эрсдэлээс амжилттай хамгаалагдан ажиллаж байна.

Болормаа: “Би даатгалыг татварын нэг төрөл гэж өрөөсгөл ойлгож байсан”

...Нөхөн төлбөрөө аваад юунд зарцуулдаг вэ гэж үү, ... мэдээж би өөрийнхөө эрүүл мэндэд зарцуулсан мөнгөө буцаан авч байгаа болохоор эрүүл мэнддээ л хөрөнгө оруулахыг хичээдэг. Жишээ нь, дархлаагаа сайжруулах витамин ч юмуу амин дэм авах, фитнес явах зардал гэх мэт. Миний ажиллаж байгаа компани бол олон улсын хөрөнгө оруулагч компани бөгөөд би анх ажилд орсоноосоо хойш Тэнгэр даатгалын эрүүл мэндийн даатгалд гэр бүлээрээ манай нөхөр, хүүгийн хамт даатгуулаад зургаан жил болж байна. Өмнө нь би даатгалыг нийгмийн даатгал гэж ойлгож сар бүр даатгалын шимтгэлийг татвар мэт төлдөг байсан. Ер нь бол бусдын адил л даатгалыг татварын нэг төрөл гэж буруу ойлголттой байсан.

Өвчин бол хэлж ирдэггүй гэж ярьдаг. Тиймдээ ч, ирээдүйгээ бодоод бас санхүүгийн зардлаа бодоод хамгийн гол нь эрүүл мэндээ бодоод Тэнгэр даатгалын эрүүл мэндийн даатгалыг сонгон даатгуулсан. Надаас гадна, манай гэр бүлийн хэн нэг нь ямар нэг өвчин тусаад эмчлүүлсэн зардлаа Тэнгэр даатгалаас нөхөн төлбөр хэлбэрээр авдаг юм.

Төмөр: “Гэр бүлээр минь даатгасанд баярлаж явдаг”

... Гэр бүлийн цөм нь юу вэ гэжүү, ... аливаа саад бэрхшээлийн үед гэр бүлээрээ аз жаргалтай байх ... гэхдээ эхнэр нөхөрийн хайр сэтгэл, хүүхдийн инээд хөөр гээд олон сайхан юм ярьж болох ч хамгийн гол нь гэр бүлийн гишүүн бүр эрүүл байх, миний бодлоор энэ л хамгийн чухал үнэ цэнэ юмуу даа гэж бодож байна. Эхнэр Болормаа маань Тэнгэр даатгалын эрүүл мэндийн даатгалд гэр бүлээрээ даатгуулсан гэж ярихад нь ямар сайхан мэдээ вэ гэж баяртайгаар хүлээн авч байсан.

Хүүхэд ч гэлтгүй би эсвэл манай эхнэр эсвэл бид гурвуулаа ханиад хүрэх, шүд өвдөх ч гэдэг юмуу хүмүүсийн хэлдэгээр бол “байдаг л” өвчин туссан ч бид дуртай эмнэлгээрээ үйлчлүүлж чаддаг. Ингэж чадаж байгаа нь бидний хувьд гэр бүлээрээ эрүүл байх маш том хөрөнгө оруулалт юмдаа.

- 
-  www.tengerdaatgal.mn
 -  +(976)-1800-1889
 -  insurance@tengerinsurance.mn
 -  /tengerinsurance